



ХӨГЖЛИЙН ЭРХ ЗҮЙН ТӨВД

**МОНГОЛ УЛСЫН ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

Метро бизнес төв, А блок 5 давхар
Д. Сүхбаатарын гудамж-13
Сүхбаатар дүүрэг, УБ 14201-0033
Утас: 30 42 58, Факс: (976-11) 32 77 20
Цахим хуудас: www.crc.gov.mn
Цахим шуудан: info@crc.gov.mn

2024.02.20 № 01/290

танай _____-ны № _____-т

Тодруулгад хариу өгөх тухай

Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын судалгаа хийх ХХЗХ/20240103040/01/01 урилгын дугаартай тендер шалгаруулалтад 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдөр гаргасан тодруулгын хариу тайлбарыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 1 хуудастай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

Харилцаа холбооны зохицуулах хорооны
2024 оны 02 сарын 20 өдрийн 01/290 тоот
албан бичгийн хавсралт

ХХЗХ/20240103040/01/01 УРИЛГЫН ДУГААРТАЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТАД
2024.02.19-НИЙ ӨДӨР ГАРГАСАН ТОДРУУЛГЫН ХАРИУ ТАЙЛБАР

№	Тодруулга	Хариу тайлбар
1	Бүсчилсэн байдлаарх судалгааг аймаг бүрийг хамруулахгүйгээр нэг бүсээс нэг аймаг сонгож болох уу?	Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын судалгааны техникийн тодорхойлолт, нөхцөл шаардлагад заасанчлан үндэсний, бүс нутгийн хэмжээнд төлөөлөх чадвартай байхаар тооцож аймаг, нийслэлээс түүвэрлэн сонгож судалгааг хийнэ. Судалгааны үр дүнг УБ хот, орон нутаг, бүсчилсэн байдлаар гаргана.
2	Мэдээлэл цуглуулах арга зүйд утсаар мэдээлэл цуглуулахыг зөвшөөрөх үү?	Мэдээлэл цуглуулахдаа утсаар холбогдож мэдээлэл цуглуулах аргыг хэрэглэж болох хэдий ч судалгааны чанарт сөргөөр нөлөөлөх байдал, хүний хувийн мэдээлэл хамгаалах эрхзүйн баримт бичгийг мөрдлөг болгохыг анхаарна уу.
3	Хичээн хүнийг хамруулах вэ?	Аймаг, Улаанбаатар хотын 9 дүүргээс улс болон бүсийг төлөөлөхүйц байхаар тооцож судалгааны арга зүйд тусган тендерийн баримт бичигт ирүүлнэ.
4	Үндэсний хэмжээнд төлөөлөхүйц судалгааг ийм бага хугацаанд буюу 70 хоногт дээрх төсвөөр гүйцэтгэх нь мэргэжлийн хувьд боломжгүй байдаг. Иймд тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулж болох уу. Зүй нь Улаанбаатар хотын хэмжээнд тэр дундаа төвийн 6 дүүргийг хамруулсан хэмжээнд судалгааг хийж болох уу энэ тохиолдолд хугацаа зардлын хувьд боломжтой байхаар байна.	Санхүүжүүлэгч байгууллагаас судалгаа гүйцэтгэх хугацааг заасан тул тендерийн баримт бичигт гүйцэтгэх хугацаатай холбоотой өөрчлөлт оруулах боломжгүй болно. Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын судалгааны техникийн тодорхойлолт, нөхцөл шаардлагын дагуу судалгааны үр дүнг УБ хот, орон нутаг, бүсчилсэн байдлаар гаргана.